

БАТЛАВ:
САЙНЦАГААН СУМЫН ГХУСАЗЗ-ИЙН
ДАРГА
Б.ӨЛЗИЙБАЯР

2018 оны 4 сарын 06-ны өдөр

"ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛГҮЙ ЦЭЦЭРЛЭГ"
АЯНЫ УДИРДАМЖ

Зорилго : Бага насны хүүхдүүдийг бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хүчирхийлэл, хулгайн гэмт хэрэг, болон зам тээврийн осол, ахуйн хүрээнд архидан согтуурсны улмаас үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд эцэг эх, байгууллагын алба хаагчдын оролцоо идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Сайнцагаан сумын СӨБ хамрагдана

Хугацаа: 2018 оны 04 сарын 09-ны өдрөөс 2018 оны 12-р сарын 01-ний өдрийг хүртэл

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. "Гэмт хэрэг, зөрчилгүй цэцэрлэг" уриалга бүхий аяны цом, хавтсыг нэг байгууллагад ажлын 5 хоног аялуулна.
2. Цом дэвтрийг хүлээн авсан байгууллага, аяны нээлтийн үйл ажиллагааг байгууллагынхаа хэмжээнд зохион байгуулан, аяны зорилгын хүрээнд тодорхой үр дүнтэй ажлуудыг байгууллагын хамт олон, эцэг эхийн хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна.
3. Аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж бүрэн хэрэгжүүлж ажиллах
4. Аяны хавтсанд зохион байгуулсан арга хэмжээний тайланг фото зургийн хамт хавсаргаж цом хавтсыг хуваарийн дагуу дараагийн цэцэрлэгт хүлээлгэн өгнө.
5. Иргэдийн өмчийн хулгай, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлсэн ажил арга хэмжээ зохион байгуулах
6. Гарч болзошгүй аюул, осол болон зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлсэн ажил арга хэмжээг зохион байгуулах
7. Архи, тамхины хор уршиг, ахуйн хүрээнд архидан согтуурах явдлаас урьдчилан сэргийлсэн ажил арга хэмжээг зохион байгуулах
8. Дээрхи гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлсэн боршур, сэрэмжлүүлэг, шторк бэлтгэж олон нийтэд сурталчлах / тараасан материалыг хүлээн авсан хүний гарын үсгээр баталгаажуулах/
9. Байгууллагынхаа гадна орчны гэрэлтүүлэг, хяналтын камераа сайжруулах /одоо байгаа болон зохион байгуулсан ажлын хүрээнд ямар өөрчлөлт гарсан тухай зургаар үзүүлэх /
10. Баяр ёслол, амралтын өдрүүдэд байгууллага дээрээ хариуцлагатай эргүүл, жижүүрийг тогтмол ажиллуулж цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах

11. Аяны хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлынхаа талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагынхаа Facebook болон цахим хуудсаар иргэд олон нийтэд сурталчлах, Сайнцагаан сумын ГХУСАЗЗ-ын пэйж хуудсанд байршуулах

Аяныг дүгнэх:

1. Уг аяныг 2 удаа зохион байгуулах бөгөөд 4,5-р сард эхний арга хэмжээг 9,10,11-р сард 2 дахь аяныг үргэлжлүүлэн зохион байгуулна.
2. Удирдамжинд заагдсан ажил, арга хэмжээ болон бусад санаачлан хэрэгжүүлсэн ажлын тайлан, холбогдох материалыг Сайнцагаан сумын ГХУСАЗЗевлөл 2018 оны 12-р сарын 15-нд нэгтгэж гаргаж дүгэнэ.

Гарах үр дүн:

1. Хамт олон, эцэг эхчүүдийн хууль, эрх зүйн мэдлэг дээшилнэ
2. Аюулгүй амар тайван орчин бүрдэнэ
3. Байгууллагын ойр орчимд гэрэлтүүлэг, хяналтын камер нэмэгдэж хүүхдийн аюулгүй байдал, багш ажилчдын амар тайван ажиллах боломж бүрдэнэ.
4. Бага насны хүүхэд бэртэж гэмтээгүй байх, байгууллагын орчинд гэмт хэрэг, зерчил үйлдэгдэхгүй байх

Анхаарах зүйл:

1. Аяны удирдамжийн дагуу ажлыг зохион байгуулах бөгөөд байгууллагууд заасан хуваарийн дагуу Цом дэвтрийг дараагийн байгууллагад хугацаа алдалгүй хүргэж өгөхийг анхаарах шаардлагатай.
2. СӨБ-ын байгууллагууд удирдамжийн хавсралтад заасан хуваарийн дагуу аяныг зохион байгуулна.

Шагнал, урамшуулал:

Сайнцагаан сумын "Гэмт хэрэг, зерчилгүй цэцэрлэг" шалгаруулна.

Тэргүүн байр - /Өргөмжлөл, мөнгөн шагнал/

Дэд байр - /Өргөмжлөл, мөнгөн шагнал /

**САЙНЦАГААН СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ**

ХАВСРАЛТ-1

**"ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛГҮЙ ЦЭЦЭРЛЭГ" аян
зохион байгуулах ажлын хуваарь**

№	Байгууллагын нэр	Аяны эхний үйл ажиллагаа		Аяны төгсгөлийн үйл ажиллагаа	
		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	1-р цэцэрлэг	2018/04/09	2018/04/13	2018/09/17	2018/09/21
2	2-р цэцэрлэг	2018/04/16	2018/04/20	2018/09/24	2018/09/28
3	3-р цэцэрлэг	2018/04/23	2018/04/27	2018/10/01	2018/10/05
4	4-р цэцэрлэг	2018/04/30	2018/05/04	2018/10/08	2018/10/12
5	5-р цэцэрлэг	2018/05/07	2018/05/11	2018/10/15	2018/10/19
6	6-р цэцэрлэг	2018/05/14	2018/05/18	2018/10/22	2018/10/26
7	7-р цэцэрлэг	2018/05/21	2018/05/25	2018/10/29	2018/11/02